



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Цахилгаан эрчим хүчний импортлох
болон экспортлох хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 19.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 онд импортоор авах цахилгаан эрчим хүчний хэмжээг 1 дүгээр хавсралтад заасан хэмжээгээр тогтоосугай.

2.Оросын Холбооны Улсад 2021 онд экспортлох цахилгаан эрчим хүчний хэмжээг 2 дугаар хавсралтад заасан хэмжээгээр тогтоосугай.

3.Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд импортоор авах цахилгаан эрчим хүчний хэрэглээг 24 цагаар төлөвлөн, цахилгаан үйлдвэрлэлийн горимд зохицуулалт хийж, сар бүр тайланг гаргаж ирүүлэхийг “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК /Г.Балжинням/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын 1 дүгээр хавсралтад заасан хэмжээгээр гэрээ байгуулан ажиллахыг цахилгаан импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

5.Цахилгаан эрчим хүч импортлох гэрээний биелэлт, цахилгаан эрчим хүчний импортын хэмжээ болон дотоодын үйлдвэрлэлийн зохистой харьцаанд хяналт тавьж, горимын зохицуулалт хийж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Батзориг/-д даалгасугай.



Н.ТАВИНБЭХ

170600087

Эрчим хүчний сайдын 2021 оны ...
дүгээр сарын ... өдрийн ... дугаар
тушаалын ... хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНД ИМПОРТЛОХ
ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМЖЭЭ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Экспортлогч улс	Цахилгаан эрчим хүч импортлож буй чиглэл	Хүчдлийн түвшин /кВ/	Импортлох цахилгаан эрчим хүчний хэмжээ /мян.кВт.цаг/
1	“ДҮТ” ХХК	ОХУ	Селендум (Бурят)-Сүхбаатар (Сэлэнгэ аймаг)	220	305,600.0
2	“ЦДҮС” ТӨХК	БНХАУ	Баяннуур (ӨМӨЗО) – Ханбогд (Өмнөговь аймаг)	220	1,407,970.0
3	“ББЭХС” ТӨХК	ОХУ	Чадан (Тува) – Боршоо (Увс аймаг)	110	131,342.1
4			Хандгайт (Тува) – Давст (Увс аймаг)	10	735.0
5			Цагаан толгой (Тува) – Арц суурь (Завхан аймаг)	10	230.0
6		БНХАУ	Тайкешикен (ШУӨЗО) – Булган (Ховд аймаг)	35	6,899.4
7			Тайкешикен (ШУӨЗО) – Ярант (Ховд аймаг)	10	406.3
8		“ДБЭХС” ТӨХК	ОХУ	Дээд Ульхан (Чита) – Майхан (Дорнод аймаг)	10
9	БНХАУ		Ар хашаат (ӨМӨЗО) – Хавирга (Дорнод аймаг)	10	168.0
10	“Хөвсгөл эрчим хүч” ХХК	ОХУ	Монды (Бурят) – Турт (Хөвсгөл аймаг, Ханх)	10	807.1
11	“ӨБЦТС” ТӨХК	БНХАУ	Ганц мод (ӨМӨЗО) – Гашуун сухайт (Өмнөговь аймаг)	10	1,930.0
12	“БЗӨБЦТС” ТӨХК	БНХАУ	Мандал (ӨМӨЗО) – Ханги (Дорноговь аймаг)	10	609.0
13	Монгол-Оросын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэг	БНХАУ	Эрээн (ӨМӨЗО) – Замын-Үүд (Дорноговь аймаг)	10	85.0
14	“Нарийн Сухайт эрчим” ХХК	БНХАУ	Сэхээ (ӨМӨЗО) – Нарийн сухайт (Өмнөговь аймаг)	35	29,325.0
НИЙТ					1,886,194.24

Эрчим хүчний сайдын 2021 оны 01
дүгээр сарын 26 өдрийн 35 дугаар
тушаалын 2 хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНД ЭКСПОРТЛОХ
ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМЖЭЭ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Импортологч улс	Цахилгаан эрчим хүч экспортлож буй чиглэл	Хүүдлийн түвшин /кВ/	Экспортлох цахилгаан эрчим хүчний хэмжээ /мян.кВт.цаг/
1	"ДҮТ" ХХК	ОХУ	Сүхбаатар (Сэлэнгэ аймаг) - Селендум (Бурят)	220	35,500.0
НИЙТ					35,500.0